

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, МОНГОЛ-ЧЕХИЙН
ПАРЛАМЕНТЫН БҮЛГИЙН ГИШҮҮН Б.ЖАРГАЛМААГИЙН
ЧЕХ УЛСЫН ҮНДЭСНИЙ БАЯРЫН ХҮЛЭЭН АВАЛТАД
ХЭЛЭХ ҮГ**

Эрхэмсэг ноён Элчин сайд Иржи Бродский,
Эрхэм хүндэт зочид оо,
Ноёд, хатагтай нар аа,

Бүгд Найрамдах Чех Улсын Үндэсний баяр – Чехословак Улсын тусгаар тогтносны 102 жилийн ойн баярыг тохиолдуулан итгэлт анд, чех нөхөддөө болон энд хуран цугласан зочид Та бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж буйг минь хүлээн авна уу.

Манай хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхэн 70 жилийн ой энэ жил тохиож байна. Энэхүү хугацаанд үргэлжилсэн Монгол, Чехийн уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд Засгийн газрын зүгээс анхаарч ажиллаж байна.

Монгол, Чехийн харилцаа, хамтын ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан үнэт зүйлсэд тулгуурлан хөгжиж ирсэн. Хоёр талын харилцаа байгаль хамгаалал, хөдөө аж ахуй, эрчим хүч, барилга, боловсрол зэрэг олон салбарт идэвхтэй хөгжиж байна. Энэхүү хөгжлийн суурь нь иргэн хоорондын харилцаа, харилцан ойлголцол байсаар ирснийг тэмдэглэе.

Монгол Улсын Засгийн газар корона вирусын цар тахлын эдийн засгийн сөрөг дагаварыг даван туулах, эдийн засгаа төрөлжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх зорилт тавин дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг батлаад байна. Эдгээрийн хүрээнд Чех Улстай цаашид худалдаа, эдийн засгийн харилцааг шинэ шатанд гаргах, харилцан ашигтай бизнесийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэх сонирхолтой байна.

Хоёр орны харилцааны чухал суурь болох Парламентын харилцаа маш идэвхтэй хөгжиж байгааг энд тэмдэглэмээр байна.

Монголчуудын эртний анд Чех Улс цар тахлаас шалтгаалан БНЧУ-д гацаад байсан монгол иргэдийг нутагт нь буцаахад чухал дэмжлэг үзүүлсэнд талархаж байна. Энэхүү ажлыг бүтээхэд дэмжиж ажилласан эрхэмсэг Элчин сайд Бродский Танд гүн талархал илэрхийлье.

Хатагтай, ноёд оо,

Өнөөгийн амаргүй үед цар тахлыг дэлхийн улс орнууд хамтын хүчээр даван туулахыг хүсэн ерөөж, энэхүү хундагыг

- Хоёр улсын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хөгжил, цэцэглэлтийн төлөө болон
- Та бүгдийн эрүүл энх, сайн сайхны төлөө өргөө.